

УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЦӨӨНХИЙН ОРОЛЦОО

П.Эрдэнэжаргал, Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал

I. АСУУДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Орчин үеийн ардчилал нь олонхын дарангуйлал бус, харин хүний суурь эрхийг дээдэлсэн, хуулийн засаглалтай, хараат бус төрийн албатай, оролцооны болон олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийн суваг, механизмуудыг бүрдүүлсэн, хяналт-тэнцэлтэй, хариуцлагатай төлөөллийн төрийн тогтолцоо юм (Bulmer, 2021).

Олон намын тогтолцоотой улсад парламентын институци нь нийгмийн янз бүрийн бүлэг, үзэл бодол, байр суурийн тусгал болдог бөгөөд парламент дахь сөрөг хүчин нь ардчиллын зайлшгүй, салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Сөрөг хүчний үндсэн чиг үүрэг нь бодлогын оновчтой алтернатив хувилбар олонход санал болгох, улмаар гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд хяналт тавих, төрийн үйл ажиллагааны ил тод, шударга, үр ашигтай байдлыг хангах, төрийн байгууллагуудын болон албан тушаалтнуудын зүгээс эрх мэдлээ урвуулан ашиглахаас сэргийлэх үндсэн дээр нийтийн эрх ашгийг хамгаалах явдал (Inter-Parliamentary Union, 2023). Иймээс парламент дахь сөрөг хүчнийг ардчилсан улс орнууд Үндсэн хуулиараа хүлээн зөвшөөрдөг байна. Ингэхдээ зарим улс үндсэн хуульдаа хууль тогтоогч цөөнхийн эрхийг дурдаж, бусад хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулдаг бол зарим улс энэхүү харилцааг үндсэн хуульдаа нэг мөр зохицуулсан ажээ (Bulmer, 2021).

Венецийн комисс 2019 онд гаргасан парламентын олонх, цөөнхийн харилцааны талаарх баримт бичигтээ сүүлийн жилүүдэд “ялагч бүхнийг шийднэ” хэмээх ардчилсан парламентад харш хандлага газар авч, улмаар парламентын олонхын эрх мэдлийг зааглах хяналт-тэнцлийн тогтолцоо алдагдаж, улс төрийн мэтгэлцээн, хэлэлцүүлэггүйгээр хууль

яаравчлан батлах, шүүх болон бусад хараат бус институцийн томилгоо, халгаа сэлгээ зөвхөн олонхоор хийгдэх явдал ажиглагдах болсныг цохон тэмдэглэжээ.

Парламентын ардчиллын нэг чухал зарчим нь улс төрийн эв нэгдлийн зарчим буюу парламент дахь олонх, цөөнх нь нийгмийн өмнө хамтын хариуцлага хүлээх явдал юм. Тэр тусмаа манай улсад сонгуульд ялсан улс төрийн намын хувьд сонгогчдоос авсан саналын хувь сүүлийн жилүүдэд буурсаар иржээ. 1992 оноос хойш явагдсан УИХ-ын найман удаагийн сонгуульд дөнгөж хоёрхон удаа (1992 онд 57.1 хувь, 2000 онд 51.5 хувь) сонгогчдын саналын 50-иас дээш хувийг авч олонх болж байсан бол сүүлийн таван сонгуульд сонгогчдын 50 хүрэхгүй хувийн саналаар УИХ-ын олонх бүрэлдсэн байна. УИХ дахь олонхын дэмжлэг ийнхүү буурсаар байгаа нөхцөлд сонгогчдын тал хувийн дэмжлэгийг авч цөөнх болсон улс төрийн өрсөлдөгч талтайгаа зөвшилцөх, парламентын үйл ажиллагаанд үр нөлөөтэй оролцох боломжийг нь нээн хамтын удирдлагын зарчмыг хэрэгжүүлэх нь туйлын чухал болохыг онцолж байна.

Хэдийгээр олонх, цөөнхийн хоорондын улс төрийн сөргөлдөөн ардчиллын хэвийн, чухал шинж боловч олонх, цөөнх аль алин нь төрийн эрх мэдлийн эзэн болох иргэдийн нийтийн эрх ашгийг урьдал болгож, түүнийг тууштай хамгаалахад хамтын болон хариуцлагатай үүрэг хүлээх шаардлагатай болдог (Venice Commission, 2019). Иймээс, сонгогдсон олонх эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ олон түмний нэг хэсгийн төлөөлөл болсон цөөнхөө хүндэлж, үр нөлөөтэй оролцох боломж, нөхцөлийг нь бүрдүүлэх, харин цөөнх нь хууль тогтоомжийн хүрээнд олгогдсон

эрхээ урвуулан ашиглахгүй байх, олонхын бодлогыг сөрж шүүмжлэхдээ хүчирхийлэл, эмх замбараагүй байдалд уриалахгүй байх, парламентын үйл ажиллагааг хүчээр саатуулахгүй байх зэрэг хэм хэмжээ, ёс зүйг эрхэмлэнэ. Сонгуульд ялснаар түрүү барин олонх өөрийн хууль ёсны эрхээ урвуулан ашиглахаас сэргийлэх механизмуудыг бүрдүүлж байж үндсэн хуулийн ардчилал нь дарангуйлагч дэглэм болж хувирах эрсдэлээс урьдчилан сэргийлж чадна.

Манай улс Үндсэн хуульдаа 2023 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу УИХ-ын гишүүдийн 40 орчим хувь нь намын жагсаалтаар сонгогдохын зэрэгцээ гишүүдийн суудлын тоо 65.7 хувиар нэмэгдээд байна. Энэхүү нэмэлт өөрчлөлтийн зорилгыг “... ард түмнийг төлөөлөх парламентын чадавхыг сайжруулах, хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг чанаржуулах замаар Монгол Улсын тусгаартогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа болсон парламентын засаглалыг төгөлдөржүүлнэ”

II. УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ ЦӨӨНХИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ЗАРИМ УЛСЫН ТУРШЛАГА

Намын бүлэг байгуулах

Парламентын цөөнхийн үүрэг, оролцоог институтчлэх нь үндсэн хуульг ардчиллын болон улс төрийн соёлын салшгүй чухал хэсэг болно. Нэг намаас сонгогдсон гишүүд үйл ажиллагаагаа уялдуулах, намынхаа зорилгыг хэрэгжүүлэхийн тулд намын бүлэг байгуулж ажиллах эрхийг аль болох саадгүй хангах нь зохистой. Олон улсад парламент дахь намын бүлэг буюу институтчлэгдсэн нэгжид парламентын хувь гишүүнтэй харьцуулахад парламентын удирдлагад оролцох, үг хэлэх, байр сууриа илэрхийлэх илүү цаг олгох, санхүүгийн болоод захиргааны нэмэлт дэмжлэг үзүүлэх зэрэг зохицуулалт үйлчилдэг байна. Парламентын цөөнх нь олонхын нэгэн адил эдгээр нэмэлт эрхийг эдлэх нь цөөнхийн эрх, үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу УИХ-д 8-аас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг байгуулж болох бөгөөд энэ нь УИХ-ын 76 гишүүний 10.5 хувь юм. Зарим улсын парламентад намын бүлэг зохион байгуулах зохицуулалттай харьцуулахад энэ нь харьцангуй өндөр босго гэж үзэж болно.

хэмээн Засгийн газраас уг хуулийн төслийг УИХ-д өргөн барихдаа онцлон тэмдэглэсэн байна. Ийнхүү УИХ-д олон намын төлөөлөл илүү болох магадлал нэмэгдсэн буюу парламентын цөөнх гишүүдийн тоо нэмэгдэх боломж бүрдэж байгаа зэрэг улс төрийн шинэ нөхцөлд хууль тогтоох, гүйцэтгэх засаглалд хяналт тавих УИХ-ын үйл ажиллагаанд цөөнхийн үр нөлөөтэй оролцоог дэмжих үүднээс УИХ-ын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжуудыг нягтлан, дүн шинжилгээ хийх шаардлага гарцаагүй үүсэж байна.

Энэхүү бодлогын шинжилгээнд парламентын цөөнхийн эрхийг баталгаажуулах асуудлыг (1) намын бүлэг байгуулах; (2) намын бүлгийн болон намын бүлэг үүсгэх хэмжээнд төлөөлөлгүй намууд, түүнчлэн бие даагчид хууль тогтоох үйл ажиллагаанд хэрхэн үр нөлөөтэй оролцох боломжтойг манай улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсын туршлагын хүрээнд авч үзлээ.

Энэ босго Канадын парламентын доод танхимд 3.6 хувь, Германы Бундестагд 5.0 хувь, Эстонийн парламентад 4.9 хувь, Өмнөд Солонгосын Үндэсний Ассамблейд 6.6 хувь байна. Тэрчлэн, Өмнөд Солонгосын Үндэсний Ассамблейн аль нэг намын бүлэгт хамрагдаагүй 20 гишүүн хамтарч бүлэг байгуулж болдог байна.

Парламентад олон жижиг бүлгүүд үүсэх нь парламентын хэвийн үйл ажиллагааг дэгийн хувьд хүндрүүлэх, зардал өсгөх зэрэг сөрөг талтайг харгалзан намын бүлэг байгуулах доод хязгаар босго тогтоодог. Намын бүлэг байгуулах босго нь хэтэрхий өндөр байвал сөрөг хүчин буюу цөөнх парламентын албан ёсны бүтцийн бүрэлдэхүүн болж институтчилэгдэн сөрөг хүчний үүргээ хэрэгжүүлэх эрхийг хязгаарлах, ардчилсан парламентын агуулгад үл нийцэх зохисгүй үр дагавартай.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль тогтоомжууд нь УИХ дахь намын бүлэг хууль тогтоох үйл ажиллагаа болон гүйцэтгэх засаглалыг хянахад чухал үүрэгтэй оролцох боломжуудыг нээж өгчээ. Иймээс УИХ-ын төлөөлөх чадварыг нэмэгдүүлэн олон намын тогтолцоог дэмжих үндсэн дээр ардчиллыг тууштай гүнзгийрүүлэн хөгжүүлэх зорилго

агуулсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтүүд бодитой хэрэгжих нөхцөл бүрдүүлэхэд намын бүлэг байгуулах босгыг оновчтой тогтоох нь чухал ач холбогдолтой. УИХ-д өргөн баригдаад байгаа УИХ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд

намын бүлэг байгуулах гишүүдийн тоог 12 болгон нэмэгдүүлж намын бүлэг байгуулах босго (УИХ-ын нийт гишүүнд эзлэх хувь)-ыг хэвээр хадгалж байгаа нь Үндсэн Хуулийн нэмэлт өөрчлөлтийн үзэл санаанд нийцээгүй гэж дүгнэж болохоор байна.

III. НАМЫН БҮЛГИЙН БОЛОН БУСАД ЦӨӨНХИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ

УИХ дахь цөөнхийн оролцоог хэрхэн зохицуулсныг Олон Улсын Парламентын Холбооноос (ОУПХ) 2023 онд боловсруулж гаргасан “Ардчилсан парламентын шалгуур үзүүлэлтүүд”-ийн парламентын цөөнхтэй холбоотой бүлэг үзүүлэлтийн дагуу УИХ-ын тухай хууль тогтоомжийн хүрээнд авч үзлээ (Inter-Parliamentary Union, 2023).

1. Парламентын хамтын удирдлагад оролцох

Парламент нь улс төрийн олон ургалч үзлийг төлөөлсөн, ижил тэгш эрхтэй гишүүдийн нэгдэл бөгөөд энэ утгаараа парламентын үйл ажиллагааны зохион байгуулалт нь хамтын шийдвэр гаргах тогтолцоо, бүтцийг зүй ёсоор шаарддаг. Хамтын удирдлагын бүтэц (тэргүүлэгчид) нь парламентын үйл ажиллагааг зохион байгуулах, хороодын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төсөл боловсруулах болон парламентын бусад үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг хүлээдэг бөгөөд бүрэлдэхүүнд нь парламентын олонх, цөөнхийн төлөөлөл, хороодын дарга нар ордог байна.

УИХ-ын үйл ажиллагааг зохицуулах дээр дурдсантай төстэй бүтэц нь УИХ-ын даргын дэргэдэх Зөвлөл юм. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу энэхүү зөвлөл нь УИХ-ын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, УИХ-ын төсөв болон УИХ-ын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой асуудлуудыг зөвшилцөх зэрэг чиг үүрэгтэй бөгөөд бүрэлдэхүүнд нь УИХ-ын дарга, дэд дарга, нам эвслийн бүлгийн дарга, Байнгын хороодын дарга, УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга нар багтдаг байна. Энэхүү Зөвлөл нь бүрэлдэхүүний хувьд болон чиг үүргийн хувьд ОУПХ-ны шалгуурыг ерөнхийдөө хангаж байгаа хэдий ч УИХ-ын даргын дэргэд ажилладаг нь анхаарал татаж байна.

УИХ-ын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх шийдвэр хэрхэн гардгийг авч үзвэл УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу

хэлэлцэх асуудлын талаарх тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хороо нам, эвслийн бүлэг, байнгын, дэд, түр хороо, хууль санаачлагчийн саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанд оруулж олонхын саналаар баталдаг бол чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг УИХ-ын дарга Зөвлөлийн саналыг харгалзан захирамж гарган тогтоодог зохицуулалттай байна. Тэрчлэн, УИХ-ын тухай хуулийн 14.1.8 дахь зүйлийн дагуу үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор Ерөнхий сайдын гаргасан хүсэлтийг үндэслэн баталсан тов, дарааллыг харгалзахгүйгээр хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх шийдвэрийг УИХ-ын дарга дангаар гаргах бүрэн эрхтэй байна.

Эдгээр зохицуулалтаас үзэхэд чуулганаар хэлэлцэх асуудал, түүний дарааллыг олонх шийдэх нөхцөл бүрдсэн гэж дүгнэж болох талтай. Энэ талаар цөөнхийн гишүүдээс гомдол санал гаргах нь цөөнгүй байдаг. Практикт Төрийн байгуулалтын байнгын хороо болон УИХ-ын даргын дэргэдэх Зөвлөл шийдвэр хэрхэн гаргадгийг судалсны үндсэн дээр УИХ-ын цөөнх УИХ-ын дотоод зохион байгуулалтын чухал асуудал болох хуулийн төсөл өргөн барих, хэлэлцэх асуудлын жагсаалт, түүний дарааллыг тогтооход ямархуу нөлөөтэй оролцдогийг бодитой дүгнэх боломж бүрдэнэ. УИХ-ын тухай хуулийн болон УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хэлэлцэх асуудал, түүний дарааллыг тогтоох зохицуулалт хэвээр хадгалагджээ.

Герман, Эстони, Канад зэрэг улсад энэхүү хамтын удирдлагын парламент дахь бүтэц бие даасан бөгөөд хамгийн чухал чиг үүрэг нь нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлын төсөл боловсруулах юм. Герман Улсын туршлагыг дэлгэрүүлэн авч үзвэл, Бундестагийн Ахмадын зөвлөл хуралдааны тов, хэлэлцэх асуудлаар саналаа нэгтгэн гишүүдэд хүргэх бөгөөд эсрэг санал гараагүй болон эхний хэлэлцэх асуудал зарлагдсан тохиолдолд батлагдсанд тооцогдоно. Нэгдсэн хуралдаан

эхэлмэгц эхний хэлэлцэх асуудал зарлагдахаас өмнө Бундестагийн аливаа гишүүн хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулах санал гаргаж болох ба энэ тухай өмнөх өдрийн 18.00 цагаас өмнө Бундестагийн Ерөнхийлөгчид мэдэгдсэн байх ёстой байдаг байна (German Bundestag, 2022).

Өмнөд Солонгос Улсын Үндэсний Ассамблей нь дотоод асуудал хариуцсан тусгай хороотой ба Ассамблейн дарга нь хуралдааны хэлэлцэх асуудал бэлтгэхдээ энэхүү хороотой зөвлөлдөх бөгөөд санал нэгдээгүй тохиолдолд Ассамблейн дарга өөрөө шийддэг байна (National Assembly, South Korea, 2023). Гэхдээ 20 гишүүн буюу гишүүдийн 6.6 хувь нь хэлэлцэх асуудал нэмж оруулах эрхтэй байна. Тэрчлэн, Франц, Их Британи, Канад зэрэг улсын парламентад сөрөг хүчинд нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлыг тогтоох боломж олгодог тусгай өдрүүд байдаг ажээ.

УИХ дахь цөөнхийн бүлэг УИХ-ыг удирдах үйл явцад оролцож ажиллах өөр нэг боломж нь УИХ-ын дэд даргын албан тушаал юм. Манайд цөөнхийн намын бүлэг нь өөрийн бүлгээс УИХ-ын дэд даргад нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд УИХ илээр санал хурааж сонгоно. УИХ-ын дэд дарга нь Байнгын, дэд, түр хороо, нам эвслийн бүлгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, УИХ-ын үйл ажиллагааны дэг, гишүүний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг чухал ажил үүрэг хариуцдаг байна.

Цаашид УИХ-ын хамтын удирдлагын бүтцийг бие даасан статустай болгож, чиг үүргийг нарийвчлан тодорхойлох, ОУПХ-ноос тогтоосон парламентын шалгуур үзүүлэлтийн нэг болох бие даагч гишүүдийн төлөөллийг оролцуулах асуудлыг судалж үзэх шаардлагатай.

2. Хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох

Үг хэлэх эрх нь парламентын гишүүний хамгийн чухал, үндсэн эрхийн нэг бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх юм (Venice Commission, 2019). УИХ-ын тухай хуулийн 8.1.9 дөх зүйлийн дагуу УИХ-ын гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух, байр сууриа илэрхийлэх, санал гаргах, хураалгах бүрэн эрх нь баталгаажжээ. Харин УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэгдсэн хуралдаанд үг хэлэх цагийг УИХ-д авсан суудалд нь хувь тэнцүүлэн намын бүлгүүдэд

хуваарилах, зөвхөн намын бүлгийн томилсон гишүүд үг хэлэх зохицуулалт тусгаж байгаа нь намын бүлэгт харьяалагдаж буй гишүүдийн үг хэлэх үндсэн эрхийг зөрчихөөр байна. Намын бүлэгт цаг хуваарилж, үг хэлэх гишүүдийг томилуулж байгаа нь хууль тогтоох үйл ажиллагаанд УИХ-д бүлэгтэй намуудын хариуцлагыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй байж болох юм. Гэхдээ энэ нь гишүүдийн нэгдсэн хуралдаанд асуулт асуух, үг хэлж оролцох эрхийг үгүйсгэх ёсгүй. Одоогийн дэгийн тухай хуулийн зохицуулалт болох асуулт асуух, үг хэлэх гишүүд хүсэлтээ гаргаж дараалалд орох журмыг хадгалан, аргагүй шаардлагатай бол тухайн хуулийн төслийг хэлэлцэх цаг хугацаанаас хамааруулан асуулт асуух, үг хэлэх гишүүдийн тоог хязгаарлаж болох юм. Зарим улсад, тухайлбал, Өмнөд Солонгос Улсын Үндэсний Ассамблейд намын бүлгүүдийн үг хэлэх цагийг тэдний суудалд хувь тэнцүүлэн хуваарилж, төлөөлж үг хэлэх хүний тоог тогтоодгийн зэрэгцээ нэгдсэн хуралдаанд гишүүн бүр 5 минут үг хэлэх эрх нь нээлттэй байна (National Assembly, South Korea, 2023).

Хууль тогтоох үйл ажиллагаанд сөрөг хүчин үр нөлөөтэй оролцсоноор асуудлыг олон талаас нь авч үзэх, тал бүрийн байр суурийг сонсох, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх, гаргасан шийдвэрийн үндэслэл зөв зүйтэйг нотлох боломж үүсдэг. Иймээс ардчилсан парламентын цөөнхтэй холбоотой шалгуур үзүүлэлтийн нэг нь цөөнх болон бие даагч гишүүдэд үгээ хэлэх боломж илүүтэй олгодог, хууль боловсруулахад нь нэмэлт дэмжлэг үзүүлдэг эсэх юм.

УИХ-ын гишүүн нам, эвслийн гишүүн, бие даагч эсэхээс үл хамааран хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл санаачлах эрхтэй бөгөөд аливаа хязгаарлалт тавигдаагүй байна. Намын бүлэг нь бодлого боловсруулахад туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын албатай бол харин намын бүлэг байгуулах боломжгүй намын гишүүд, бие даагчдын хувьд энэ дэмжлэг байхгүй бөгөөд зөвхөн гишүүн бүрд олгодог төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Иймээс УИХ-д нам байгуулах босгыг бууруулах эсвэл бусад улсын парламентын сайн туршлага (тухайлбал, Өмнөд Солонгос Улс)-ын дагуу цөөн суудалтай намууд болон бие даагчид нийлж бүлэг байгуулах эрхийг нээх нь чухал байна. Засгийн газраас болон олонхоос санаачилсан хуулийн төслийг хэлэлцэхэд цөөнхөд илүүтэй цаг

олгох нь зохимжтой хэмээн Венецийн комиссын зөвлөмжид дурджээ (Venice Commission, 2019). УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулиар олонх цөөнхөөс үл хамааран асуулт асуух, үг хэлэхээ урьдчилан мэдэгдэж, дараалалд ордог бөгөөд цөөнхөд тусгайлан нэмэгдэл цаг олгох зохицуулалт байдаггүй. Намын бүлэггүй нам болон бие даагч гишүүний хувьд гишүүн бүрийн нэгэн адил урьдчилан мэдэгдэж асуулт асуух, үг хэлэх дараалалд орж тогтоосон цагийг баримтлах бөгөөд хэлэлцэх асуудал тогтоох, санал дүгнэлт хэлэх нэмэгдэл цаг авах зэрэг аливаа хэлбэрээр хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох давуу эрх олгогдоогүй байна.

УИХ дахь намын бүлэгт хэлэлцэж байгаа асуудлаар бодлого байр сууриа тодорхойлж санал дүгнэлт гарган Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар шууд хэлэлцүүлэх, чуулганаар хэлэлцэх асуудал, түүний дарааллын талаар саналаа илэрхийлэх, хуулийн төслийг чуулганаар хэлэлцэх эсэх тухай санал дүгнэлт гаргах, түүнийгээ танилцуулах тусгайлан олгосон цагтай, завсарлага авах зэрэг нэлээд өргөн хүрээний эрх хуулиар олгогджээ. Тэгсэн хэдий ч УИХ-ын аливаа шийдвэр олонхын саналаар гардаг тул эдгээр эрх бодит байдалд үр нөлөөтэй зөвшилцөх нөхцөлийг бүрдүүлэх хөшүүрэг болж чадах эсэх нь эргэлзээтэй. Иймээс парламентын шийдвэр гаргах процесст намуудын оролцоог хангах чухал механизм нь хуралдааны ирц болон хууль батлах саналын хувь юм. Монгол Улсын Үндсэн Хуулийн 27.6 дахь заалтын дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.1 дэх зүйлийн дагуу гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хуралдааны ирц хангагдсанд тооцогдох бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37.3 дахь зүйлд заасанчлан үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар, хуулийг УИХ-ын гишүүдийн олонхын саналаар тус тус эцэслэн баталж байна. Эдгээр зохицуулалт нь үндсэндээ олонх УИХ-аар хэлэлцэгдэж буй хууль болон бусад бүхий л шийдвэрийг дангаар гаргах нөхцөлийг бүрдүүлж байна.

Цаашид цөөнхийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндсөн, төрийн хариуцлага, хяналтад хамаатай гэх мэт тодорхой асуудлыг шийдэхэд өндөр босго тавьдаг олон улсын туршлагыг судалж үзэх нь зүйтэй байж болох юм. Венецийн комисс Парламентын хороодын бүтэц, өмч хамгаалах, эвлэлдэн нэгдэх

эрх, улс төрийн сонгуультай холбоотой органик хуулиудыг батлах, шүүгчдийн болон төв банкны томилгоо хийх зэрэг асуудлуудыг гишүүдийн гуравны хоёрын саналаар эцэслэн шийдэж байхын зэрэгцээ парламентын дэг, бусад дотоод асуудлыг зохицуулсан хууль тогтоомжийг мөн гуравны хоёрын саналаар шийдэж байхыг зөвлөжээ (Venice Commission, 2019).

3. Гүйцэтгэх засаглалд хяналт тавих

Парламентын хяналт нь парламентын үндсэн чиг үүргийн нэг бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хангах, хүн амын аж байдлыг сайжруулах, төрийн хариуцлага, ил тод байдлыг дээшлүүлэх зорилго бүхий үйл ажиллагаа юм. Парламентын энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд парламент дахь сөрөг хүчин нэн чухал үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ үр нөлөөтэй биелүүлэх боломж, нөхцөлөөр хангагдах ёстой. Венецийн комисс 2019 онд баталсан парламентын олонх, цөөнхийн харилцааны талаарх баримт бичигтээ цөөнхийн зүгээс гүйцэтгэх засаглалд хяналт тавих арга, хэрэгслүүдийн талаар дэлгэрэнгүй тусгасныг үндэслэн УИХ дахь цөөнх энэхүү хяналтын үүргээ гүйцэтгэх боломж нөхцөлөөр хэрхэн хангагдаж буйг авч үзлээ (Venice Commission, 2019).

Монгол Улсын Их хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн холбогдох заалтын дагуу УИХ нь Засгийн газрын гишүүн, УИХ-д ажлаа тайлагнадаг бусад байгууллагын удирдлагад асуулга, асуулт тавьж хариулт авах, хяналтын сонсгол хийх, хянан шалгах түр хороо байгуулах зэргээр Засгийн газарт хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх боломжтой. Засгийн газрын гишүүн, УИХ-д ажлаа тайлагнадаг бусад байгууллагын удирдлагад асуулга, асуулт тавьж хариулт авах эрх УИХ-ын гишүүн бүрд нэгэн адил нээлттэй байна. Харин Венецийн комиссоос зөвлөмж болгодог цөөнхөд илүүтэй боломж олгосон тусгайлсан зохицуулалт манайд байхгүй байна.

УИХ дөрвөн төрлийн хяналтын сонсгол зохион байгуулах зохицуулалттайгаас цөөнхийн бүлэг хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын, ерөнхий хяналтын сонсгол хийх хүсэлт гаргах эрхтэй бол төсвийн хяналтын, нэрдэвшигчийн сонсгол хийх хүсэлтийг УИХ-ын 9-өөс доошгүй гишүүн гаргаснаар холбогдох Байнгын хороо, дэд хороо зохион байгуулна. Монгол Улсын Их Хурлын

хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгад төсвийн хяналтын сонголыг цөөнхийн бүлэг санаачилж болохоор өөрчлөлт оруулж буйг тэмдэглүүштэй. Харин одоогийн хуулиар дээрх дөрвөн төрлийн сонголыг 9 гишүүн санаачилж болохыг шинэчилсэн найруулгаар 15 болгож өөрчлөхөөр тусгасан нь Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн үзэл баримтлалд үл нийцсэн, намын бүлэггүй нам болон бие даагч гишүүдийн хяналтын сонголт зохион байгуулах хүсэлт гаргах эрхийг хязгаарласан зохицуулалт болжээ.

Хянан шалгах түр хорооны хувьд Үндсэн Хуулийн 28.2 дахь заалтын дагуу УИХ-ын гишүүдийн дөрөвний нэгийн саналаар цөөнхийн төлөөллийг оролцуулан заавал байгуулахаар зохицуулагдсан байна. Венецийн комисс хянан шалгах түр хороо байгуулах санал гаргах эрх намын бүлэгт болон парламентын гишүүдийн 1/4-д хадгалагдах нь зүйтэй гэж үздэг ч энэхүү босгыг 1/5 болгож бууруулах нь парламент дахь жижиг намуудын үүрэг оролцоог дэмжих ач холбогдолтойг тэмдэглэжээ (Parliamentary Assembly, 2024). Бүрэлдэхүүний хувьд манайд олонх, цөөнхийн төлөөллийг хувь тэнцүүлэх боловч 1/3-ээс доошгүй нь цөөнхийн төлөөлөл байх, нам, эвсэл бүрийн төлөөллийг оролцуулах зарчим үйлчилж байна. Хорооны хуралдааныг гишүүдийн 1/4 -ээс доошгүй нь шаардсанаар хуралдуулж, нийт гишүүний олонх хүрэлцэн ирснээр хуралдааныг хүчинтэй гэж үзэж олонхын саналаар асуудлыг шийднэ. Нотлох гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах санал хураалтаар цөөнх болсон гишүүн тухайн асуудлаар үндэслэлээ тайлбарлаж, гурав хүртэл удаа санал хураалгаж болно. Энэхүү зохицуулалт хуралдааны дэгээр зарим эрх цөөнхөд олгох талаарх Венецийн комиссын зөвлөмжийг хангаж байна. Тэрчлэн, түр хорооны тайлан гаргахад цөөнх болсон гишүүн тусгай санал бичгээр гаргаж тайланд хавсаргах эрхтэй бөгөөд энэ тухайгаа түр хорооны санал дүгнэлтэд тусгуулдаг зохицуулалт ч нэгэн адил Венецийн комиссын цөөнхийн тайланг тусдаа гаргах тухай зөвлөмжид нийцэж байна.

Парламентын гишүүдийн гүйцэтгэх засаглалд хяналт тавих хамгийн чухал механизм нь итгэл үл үзүүлэх санал хураалт явуулах эрх юм. Улсын Их Хурлын гишүүдийн 1/4-ээс доошгүйн саналаар Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг УИХ-ын чуулганаар авч хэлэлцдэг. Германы Бундестаг мөн

гишүүдийн 1/4-ийн саналаар Холбооны Канцлерт итгэл үл үзүүлэх (Inter-Parliamentary Union, 1999) санал хураалт явуулах зохицуулалттай бол Эстонийн парламентад Ерөнхий сайд, сайдад итгэл үл үзүүлэх санал хураалт явуулах босго гишүүдийн 1/5-ээс доошгүй байна.

Засгийн газрын зүгээс тогтмол мэдээлэл өгөх, тайлагнах нь УИХ-аас гүйцэтгэх засаглалд хяналт тавих бас нэг чухал хэлбэр болно. Үүнд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний жил бүрийн хаалттай мэдээлэл, Ерөнхий сайдын 14 хоног тутмын мэдээлэл, шаардлагатай бол цаг үеийн тулгамдсан асуудлаар Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн тухай бүр хийх мэдээлэл зэрэг орж байна. Энэ нь Венецийн комиссын зөвлөмжид нийцэж байгааг тэмдэглэхийн зэрэгцээ зарим хараат бус институцийн болон төрийн өмчит томоохон компанийн удирдлагын тайлан мэдээлэл сонсох, цөөнхөд асуулт асуух цаг, боломж илүүтэй олгох зэргийг зөвлөмж болгосныг дурдах нь зүйтэй.

Венецийн комиссын баримт бичигт дурдагдсан гүйцэтгэх засаглалд цөөнхийн зүгээс хяналт тавих хүчирхэг хэрэгсэл гэж тодорхойлсон *interpellation* буюу парламентын гишүүд асуулт тавих, асуулга тавихаас ялгаатай, зөвхөн цөөнх засгийн газрын тодорхой үйлдэл, бодлоготой холбоотой асуулт тавьж, нийт гишүүнийг хамарсан хэлэлцүүлэг өрнүүлдэг, тусгай журмын дагуу зохицуулагддаг механизм анхаарал татаж байна. Жишээлбэл, Европын зарим орон энэхүү механизмыг хэрэгжүүлдэг бөгөөд Литва Улсад парламентын гишүүдийн 1/5, Финланд Улсад 20 гишүүн (10 хувь), Хойд Македон Улсад 120 гишүүний 5 нь (4.1 хувь), Нидерланд Улсад 150 гишүүний 30 (20 хувь) нь шаардсанаар энэхүү процедур хэрэгждэг байна.

4. Парламентын бүтэц дэх оролцоо

УИХ-ын хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагааны ихэнх нь УИХ-ын Байнгын хороодод явагддаг тул уг хороодыг хууль тогтоох үйл ажиллагааны “гал тогоо” гэж хэлж болно. УИХ-ын тухай хуулийн 23.1 дэх заалтад УИХ-ын Байнгын хороодыг хууль, бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх УИХ-ын хяналтыг хэрэгжүүлэх, УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах чиг үүрэгтэй гэж заажээ. Иймээс Байнгын хороодыг хэрхэн бүрэлдүүлж,

хэн удирдаж, ямар ирцтэй хуралдаж, саналын хэдэн хувиар шийдвэр гаргаж байгаагаас хороодын үйл ажиллагааны үр нөлөө, хариуцлагын түвшин хамаарахаас гадна нь олонхын зүгээс цөөнхийн эрхэд хэрхэн хандаж байгаагийн илрэл болдог байна.

УИХ Байнгын хороодыг бүрдүүлэхдээ олонх, цөөнхийн харьцаа болон нам, эвслийн УИХ-д авсан суудлын хувийг харгалзах зохицуулалттай. УИХ-ын тухай хуулийн 26.4 дэх зүйлийн дагуу байнгын хорооны даргыг УИХ-д сонгогдон ажилласан туршлагыг нь харгалзан тухайн байнгын хорооны гишүүдээс сонгох хэдий ч практикт олонх болсон намын төлөөлөл сонгогдож иржээ. Харин Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, Сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс, бүлэг байхгүй бол цөөнхийн төлөөллөөс сонгохоор хуульчилжээ.

Олон улсын туршлагаас үзэхэд байнгын хороодын бүрэлдэхүүн нь парламентын олонх, цөөнхийн харьцааны тусгал болдог хэдий ч цөөнхийн эрх, хариуцлагыг нэмэгдүүлэхтэй холбоотой зөвлөмжийг зарим олон улсын байгууллага гаргасан байна. Тухайлбал, Европын зөвлөлийн Парламентын ассамблей төсөв, санхүү, аудитад хяналт хэрэгжүүлдэг холбогдох хороодоос гадна аюулгүй байдал, тагнуулын байгууллагын үйл ажиллагааг хариуцсан хороог сөрөг хүчин даргалах нь зохистой гэж зөвлөжээ (Parliamentary Assembly, 2024). Венецийн комиссоос төсөв, санхүү болон аюулгүй байдлын хорооны бүрэлдэхүүнд олонх, цөөнхийн харьцаанаас давуулан цөөнхөд нэмэлт суудал олгох, эсвэл эдгээр хорооны даргаар цөөнхийн төлөөлөл сонгохыг зөвлөдөг байна (Venice Commission, 2019). Герман, Франц, Их Британи, Канад зэрэг улсад төсөв санхүү хариуцсан хороодын дарга нар нь сөрөг хүчний төлөөлөл байдаг аж.

Тэрчлэн, парламент нь нам бус, мэргэжлийн ажлын албатай байх шаардлага зүй ёсоор тавигддаг байна (CPA Benchmarks, 2018). Ялангуяа, албаны дарга болон хэвлэлийн төлөөлөгчийн томилгоог парламент дахь төлөөллүүдийг бүрэн хамруулсан зөвлөлдөх үйл явцын үр дүнд, эсвэл зөвшилцлийн үндсэн дээр олонхын нөлөөнөөс ангид хийх ба томилгооны хугацаа нь тухайн парламентын бүрэн эрхийн хугацаанаас урт байх нь чухал гэжээ (Venice Commission, 2019).

5. УИХ-аас томилогддог хараат бус институциудийн удирдлагын томилгоон дахь оролцоо

Засаглалын дөрөвдөх салаа мөчир гэгддэг зохицуулалтын болон хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг институциудийн үйл ажиллагаа бие даасан, хараат бус байх нь нийгэмд шударга ёс төлөвшиж, ардчилсан засаглалын чанар сайжирч, улмаар иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдэхэд чухал нөлөөтэй. Иймээс эдгээр институцийн бүрэлдэхүүний томилгоог улс төржилтөөс аль болохоор ангид, хараат бусаар явуулахыг зорьж, сонгох, нэр дэвшүүлэх, томилох журам нь парламент дахь намуудын зөвшилцөлд тулгуурладаг байх нь ардчилсан сайн засаглалын тулгуур зарчмын нэг юм.

Нийтийн сонсголын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу зарим хараат бус институцийн удирдлагыг УИХ-аас томилохдоо нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулах болсон нь томилгоог нээлттэй явуулах боломжийг бүрдүүлсний зэрэгцээ зарим институцийн хувьд мэргэжлийн өөрөө удирдах ёсны зарчмыг хэсэгчлэн нэвтрүүлсэн билээ. Хавсралт хүснэгтэд авч үзсэн хараат бус болон хяналт зохицуулалтын чиг үүрэг бүхий 18 байгууллагын 19 төрлийн албан тушаалтны томилгоог УИХ нэр дэвшигчийн сонсгол явуулах үндсэн дээр хийж байна.

Дээд шүүхийн шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвших эрх нээлттэй буюу иргэн нэрээ дэвшүүлэх боломжтой бол бусад институцийн хувьд УИХ-ын дарга, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, холбогдох төрийн байгууллага, зарим мэргэжлийн холбоо нэр дэвшүүлэх зохицуулалт үйлчилж байна. УИХ-ын дарга Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Ерөнхий аудитор, Монгол Банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны дарга зэрэг зургаан албан тушаалд дангаар нэр дэвшүүлэх, Үндсэн хуулийн цэцийн УИХ-аас нэр дэвшүүлдэг гурван гишүүнд холбогдох Байнгын хорооны санал дүгнэлтийг үндэслэн санал болгох зохицуулалт үйлчилж байгаагаас үзэхэд хяналт, зохицуулалтын чухал үүрэг бүхий институциудийн

удирдлагад нэр дэвшүүлэхэд олонхын бүлгээс сонгогдсон УИХ-ын дарга илт давуу оролцох боломж олгожээ. Харин Шүүхийн ерөнхий зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисс, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголт зохион байгуулахад олон талын төлөөлөлтэй тусгай ажлын хэсэг байгуулагдан нэр дэвшигчдээс сонгон шалгаруулалт хийж Байнгын хороонд санал болгож байгаа нь томилгооны хараат бус байдлыг хангахад чухал үүрэгтэйг тэмдэглүүштэй.

Холбогдох байнгын хороо нэр дэвшигчийн сонголт явуулахдаа УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу нэр дэвшигчээс асуулт асуух Байнгын хорооны гишүүдийн дарааллыг тогтоохдоо олонх, цөөнхийн төлөөлөл ээлжлэн асуух боломж олгохын зэрэгцээ олонх, цөөнхийн төлөөлөл ээлжлэн үг хэлэх журамтай байгаа нь томилгоонд олонх, цөөнхийн оролцоог тэнцвэртэй хангахад ач холбогдолтой хэдий ч шийдвэр хуралдаанд оролцсон байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар гарч байна.

Хараат бус институциудийн томилгооны олонхоос хараат байдлыг бууруулах олон улсын сайн туршлагаас үзэхэд манайд парламентын цөөнхтэй зөвшилцөх тусгайлсан механизм үгүйлэгдэж байна. Улс төрөөс хараат бус байдлыг хангах шийдлүүдийн нэг нь парламентын гишүүдийн 2/3-ын саналаар томилгоо хийх явдал юм. Гэхдээ эрх баригч нам парламентын 2/3 ба түүнээс дээш суудалтай нөхцөлд дангаараа шийдвэр гаргах тул энэхүү механизм ямар ч ач холбогдолгүй болох бөгөөд харин ч ээлжит сонгуулийн үр дүнгээр парламентын олонх, цөөнхийн харьцаа өөрчлөгдсөн нөхцөлд томилгоо хийхэд төвөгтэй нөхцөл үүсгэх,

IV. САНАЛ ЗӨВЛӨМЖ

УИХ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулга, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, УИХ-ын хяналт шалгалтын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгөх санал. Үүнд:

1. УИХ-д намын бүлэг байгуулах одоогийн зохицуулалтыг хэвээр хадгалах. Энэ тохиолдолд намын бүлэг байгуулах босго нь нийт гишүүний 6.3 хувь болох бөгөөд Сонгуулийн хуулийн дагуу нам, эвсэлд суудал хуваарилах 4, 5, 7 гэсэн хувьтай уялдана. Тэрчлэн, манай улс туршлагыг

өмнөх парламентын олонхын нөлөөг цоожлох эрсдэлтэй. Нөгөө талаар сөрөг хүчин нь тухайн томилгоог зогсоох хэмжээний суудалтай бол 2/3-ын зохицуулалт томилгоог гацааж, төрийн чухал чиг үүргийг цалгардуулах магадлалтай. Иймээс олонх, цөөнхийг зөвшилцөлд хүргэх үр нөлөөтэй зохицуулалт шаардлагатай болдог байна. Тухайлбал, эхний санал хураалтаар гишүүдийн 2/3 нь дэмжээгүй бол томилгоо хийх саналын хувийг бууруулах, тэрчлэн олонх, цөөнх зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд томилох эрхийг хөндлөнгийн этгээдэд шилжүүлэх, томилгоог гацаах үйл явц нь цаг хугацааны хувьд тодорхой хязгаартай байх зэрэг ажээ (Venice Commission, 2019).

Парламентаас хараат бус институцийн бүрэлдэхүүнийг томилох шийдвэр гаргахад олонх давамгайлахаас сэргийлэх бусад үр дүнтэй арга механизм нэвтрүүлсэн олон улсын туршлага цөөнгүй. Үүнд, тухайн байгууллагын гишүүдийн томилгоог олонх, цөөнхийн суудлыг харгалзан хувь тэнцүүлж оногдуулах, эсвэл цөөнхөд тодорхой квот олгох, нэр дэвшигчдийн эхний сонгон шалгаруулалтын процессыг цөөнх хариуцах, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагуудаас нэр дэвшүүлэх боломж олгох зэрэг процесс байна. Тухайлбал, Өмнөд Солонгосын парламент Үндсэн хуулийн шүүхийн гурван гишүүний томилгоог хийх эрхтэй бөгөөд ингэхдээ олонх, цөөнх тус бүр нэг гишүүний нэр дэвшүүлдэг, үлдсэн нэг гишүүний нэрийг зөвшилцөж дэвшүүлдэг бичигдээгүй хууль үйлчилдэг. Тэрчлэн, нэр дэвшигчийн сонголт зохион байгуулах тусгай хороог парламентын дарга нь намын бүлэг бүрийн төлөөлөлтэй зөвлөлдсөний дагуу байгуулдаг байна.

нь судалдаг дээр дурдсан зарим улсын жишигт дөхөх юм.

2. Нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэг, мэтгэлцээнд УИХ дах суудлын тоонд нь хувь тэнцүүлэн цаг хуваарилах зохицуулалт шинээр оруулсан ч гишүүний нэгдсэн хуралдаанд асуулт асууж, үг хэлж оролцох эрхийг хэвээр хадгалах.
3. УИХ-ын хяналтын сонголт санаачлах гишүүдийн тоог нэмэгдүүлэхгүй буюу 9 хэвээр байлгах.

4. УИХ-ын даргын дэргэдэх Зөвлөлийг парламентын бие даасан бүтэц болгох
5. УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, хэвлэлийн төлөөлөгчийг цөөнхтэй зөвшилцсөний үндсэн дээр томилдог байх
6. Төрийн өмчит томоохон компаниудын эдийн засагт үзүүлж буй нөлөөг харгалзан, тэдгээр компанийн удирдлагын тайлан, мэдээллийг УИХ дээр сонсдог болох.
7. УИХ-ын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд цөөнхтэй зөвлөлдөх, цөөнхийн оролцоог нэмэгдүүлэх арга механизмууд
8. Өмч хамгаалах, эвлэлдэн нэгдэх эрх, улс төрийн сонгуультай холбоотой органик хуулиудыг батлах, шүүгчид болон бусад хараат бус институцийн удирдлагыг томилох үйл явцад цөөнхтэй зөвшилцөх, оролцоог нэмэгдүүлэх арга механизмууд зэрэг болно.

Цаашид судалж үзэх асуудлуудын талаарх санал.
Үүнд:

ХАВСРАЛТ

Хараат бус институциудийн томилгооны зохицуулалт

№	Албан тушаал	Нэр дэвшүүлэгч	Нэр дэвшигчийн сонголт хийх эсэх
Ерөнхийлөгч томилох албан тушаал			
1.	Дээд шүүх 25 шүүгч	Иргэн нэрээ дэвшүүлэх хүсэлт гаргана	Танилцах сонголт
2.	Ерөнхий прокурор	Ерөнхийлөгч	Нэр дэвшигчийн сонголт
3.	Ерөнхий прокурорын орлогч	Ерөнхийлөгч Ерөнхий прокурорын саналыг үндэслэн	Нэр дэвшигчийн сонголт
Улсын Их хурал томилох албан тушаал			
4.	Үндсэн хуулийн цэц 9 гишүүн	Ерөнхийлөгч 3 хүний нэр; УДШ 3 хүний нэр; УИХ нэр дэвшүүлэх 3 хүний нэр; УИХ-ын дарга 3 хүний нэр /зохих байнгын хороодын саналыг үндэслэн/	Нэр дэвшигчийн сонголыг түдгэлзүүлсэн
5.	Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгч бус 5 гишүүн	Иргэн нэрээ дэвшүүлэх хүсэлт гаргана	Томилгооны сонголт
6.	Шүүхийн сахилгын хороо шүүгч бус 5 гишүүн	Иргэн нэрээ дэвшүүлэх хүсэлт гаргана	Нэр дэвшигчийн сонголыг түдгэлзүүлсэн
7.	Хүний эрхийн үндэсний комисс 6 гишүүн	Иргэн нэрээ дэвшүүлэх хүсэлт гаргана	Нэр дэвшигчийн сонголт

№	Албан тушаал	Нэр дэвшүүлэгч	Нэр дэвшигчийн сонголт хийх эсэх
8.	Авлигатай тэмцэх газрын дарга	Ерөнхий сайд	Томилгооны сонголт
9.	Авлигатай тэмцэх газрын дэд дарга	Авлигатай тэмцэх газрын дарга	Томилгооны сонголт
10.	Сонгуулийн ерөнхий хороо 9 гишүүн	УИХ-ын ТББ-ын хороо 5 хүний нэр; Ерөнхийлөгч 2 хүний нэр; УДШ төрийн жинхэнэ албан хаагчид санал болгосноор 2 хүний нэр	Нэр дэвшигчийн сонголт
11.	СЕХ-ны дарга	УИХ-ын дарга хорооны гишүүдийн дотроос	үгүй
12.	СЕХ-ны нарийн бичгийн дарга	УИХ-ын дарга хорооны гишүүдийн дотроос	үгүй
13.	Ерөнхий аудитор	УИХ-ын дарга	Нэр дэвшигчийн сонголт
14.	Монгол банкны ерөнхийлөгч	УИХ-ын дарга	Нэр дэвшигчийн сонголт
15.	Монгол банкны тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч	Монгол банкны ерөнхийлөгч	Нэр дэвшигчийн сонголт
16.	Монгол банкны хяналтын зөвлөлийн дарга	УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо	Нэр дэвшигчийн сонголт
17.	Монгол банкны хяналтын зөвлөл 6 гишүүн	УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо	
18.	Санхүүгийн зохицуулах хороо 6 гишүүн	УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо 2 хүний нэр; Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монгол банкны Ерөнхийлөгч тус бүр 1 хүний нэр	Нэр дэвшигчийн сонголт
19.	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	УИХ-ын дарга	Нэр дэвшигчийн сонголт

№	Албан тушаал	Нэр дэвшүүлэгч	Нэр дэвшигчийн сонголт хийх эсэх
20.	Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга	УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо	Нэр дэвшигчийн сонголт
21.	Үндэсний статистикийн хороо	УИХ-ын дарга	Нэр дэвшигчийн сонголт
22.	Төрийн албаны зөвлөл 5 гишүүн	УИХ-ын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, ЗГ-ын Хэрэг эрхлэх газар тус бүр 1 хүний нэр; Төрийн албан хаагчийн төлөөлөл 2 хүний нэр дэвшүүлнэ.	Нэр дэвшигчийн сонголт
23.	ОНРТ-ийн Үндэсний зөвлөл 15 гишүүн	Ерөнхийлөгч 4 хүний нэр; ТББ-уудын саналаас сонгон; УИХ 7 хүний нэр; Засгийн газар 4 хүний нэр	Нэр дэвшигчийн сонголт
24.	Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 7 гишүүн	Иргэн нэрээ дэвшүүлэх хүсэлт гаргана	Нэр дэвшигчийн сонголт
25.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл 9 гишүүний 6	Даатгуулагч болон ажил олгогчийг төлөөлөх тус бүр 3 хүний нэрийг даатгуулагч болон ажил олгогчийн төлөөллийн байгууллага дэвшүүлнэ.	Нэр дэвшигчийн сонголт
Ерөнхий сайд томилох албан тушаал			
26.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл 9 гишүүний 3	Засгийн газрыг төлөөлөх 3 хүн албан тушаалаар;	Үгүй
27.	Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга	Нэр дэвшүүлэх зохицуулалт байхгүй	үгүй
28.	Харилцаа холбооны зохицуулах хороо 6 гишүүн	Нэр дэвшүүлэх зохицуулалт байхгүй	үгүй
29.	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 8 гишүүн	Ерөнхий сайд дарга, орон тооны 2, орон тооны бус 3 хүний нэр; МХАҮТ, МҮЭ, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ тус бүр 1 хүний нэр	

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- 2023-05-03, 3. г. (2023). *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцээд УИХ-д өргөн барилаа.*
- Bulmer, E. (2021). *Opposition and legislative Minorities: Constitutional Roles, Rights and Recognition. International IDEA Constitution-Building Primer 22.* International IDEA.
- (2018). *CPA Benchmarks.* Commonwealth Parliamentary Association.
- German Bundestag. (2022). *Rules of Procedure of the german Bundestag and Rules of Procedure of the Mediation Committee.*
- (2023). *Indicators for Democratic Parliaments.* Inter-Parliamentary Union.
- National Assembly, South Korea. (2023). *National Assembly Act.*
- (1985). *Parliament of Canada Act.*
- Parliamentary Assembly, Council of Europe. (2024). *The relationship between the parliamentary majority and the opposition in a democracy. Parliamentary Assembly, Council of Europe.*
- (2008). *Procedural guidelines on the rights and responsibilities of the opposition in a democratic parliament.* Parliamentary Assembly, Council of Europe.
- (2003). *Riigikogu Rules of procedure and Internal Rules Act, Estonia.*
- Staddon, A., & Toornstra, D. (2010). *Participants' Statement at the International Conference on benchmarking and Self-Assessment for Democratic Parliaments* Paris, 2-4 march 2010.
- Venice Commission. (2020). *Parameters on the relationship between the parliamentary majority and the opposition in a democracy: A checklist.* Strasbourg.
- (2024). *Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.*
- (2020). *Монгол Улсын Их Хурлын тухай хууль.*
- (2024). *Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.*
- (2021). *Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль.*
- (2020). *Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль.*
- (2024). *Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.*